



**НИЙСЛЭЛИЙН
ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2021 оны 06 сарын 22 өдөр

Дугаар А/316


Улаанбаатар хот

Хан-Уул дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх “Эко-Эрүүл дүүрэг” үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.5 дахь хэсэг, Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Хан-Уул дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх “Эко-Эрүүл дүүрэг” үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г нэгдүгээр, “Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин”-г хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадын байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж ажиллахыг хэлтэс, албадын дарга нарт даалгасугай.
3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг жил бүрийн дүүргийн төсвийн хүрээнд шийдвэрлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, биелэлт, хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар хууль, журмын дагуу тайлагнан ажиллахыг дүүргийн Засаг даргын Тамгын газар (С.Энхбаяр)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ж.АЛДАРЖАВХЛАН

THE UNIVERSITY OF
MICHIGAN LIBRARY
ANN ARBOR, MICHIGAN

1955